

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ БИЕЛЭЛТ**

2024 оны 10 дугаар сарын 25

Баян -Өндөр сум

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
1	1.	<p><b>2013.03.14 Дугаар 21</b>  <b>Аймгийн музей, сумдын орон нутаг судлах танхим, Шанхын баруун хүрээ хийдийн үзмэр, эд өлгийн зүйлсийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах тухай.</b>                      2.Сумдын орон нутаг судлах танхимын тохижилт үзмэрийн дэглэл, хадгалалт хамгаалалтыг сайжруулан, дохиоллын систем нэвтрүүлэх, орон нутгийн соёлын өвийг сурталчлах төв болгон хөгжүүлэхэд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн, шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>2023 онд сумын орон нутаг хөгжүүлэх сангийн төсвөөр шилэн хорго 2ш ханын обой, үзвэр байрлууллуулах баннер, 4840.000 төгрөг хандиваар илүүр 1ш 15.000 аар орон нутаг судлах танхимд баяжилт хийсэн. ОНСТ-ыг шинэ тасалгаанд шилжүүлэн хамгаалалтыг сайжруулан камержуулсан. СӨББ-тай хамтран музей үзэх өдөр арга хэмжээг зохион байгуулж, ахлах бүлгийн 2 ангийн 28 хүүхдийг хамруулсан.</p>	90%	
2	2.	<p><b>2015.07.03 Дугаар 53</b>  <b>Хүүхэд хамгааллын бодлого батлах тухай. (2015-2024)</b>                      3.“Хүүхэд хамгааллыг бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шат тус бүрээр гаргаж, шаардагдах</p>	<p>“Хүүхэд хамгааллын бодлого”-ын дагуу хүүхэд хамгааллын багийг шинэчлэн байгуулж хичээлийн жил бүр ажлын төлөвлөгөө гарган ажилладаг.                      Хүүхэд хамгааллын бодлого,ёс зүйн дүрэмтэй бүх багш, ажилчдыг танилцуулан</p>	90%	

		<p>хөрөнгийг жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган батлуулж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжаар хэрэгжих хөтөлбөр төсөлтэй уялдуулан шийдвэрлэж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж, мөрдүүлж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>4.Бодлогын хэрэгжилтэд хяналт үнэлгээг жил бүр хийж, тайланг нэгтгэн 2 жил тутамд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, үр дүнг иргэд, олон нийт, хүүхэд багачуудад мэдээлж байхыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>баталгаажуулж ажилладаг. Тэмцээн, уралдаанд явах сурагчдын эцэг,эх,асран хамгаалагчдаар зөвшөөрлийг бичгээр авч ажиллаж байна.</p> <p>2024 онд Хүүхэд хамгааллын зардал <b>3.919.900₮</b> төсөвлөгдсөнөөс</p> <p>1. “Байгальд ээлтэй залуусын чуулга уулзалт” – хүүхдийн чуулганд <b>-513.800₮</b></p> <p>2.Дотуур байрны сурагчдын эмийн зардал-<b>53000₮</b></p> <p>3.40,80 байр,бага сургуулийн камержуулалт-<b>1.600.000₮</b></p> <p>4.Эмзэг бүлгийн 2 сурагчид бичгийн хэрэгсэл-<b>46400₮</b></p> <p>5. Сургуулийн гадна 00-ын гэрэлтүүлэг-2ш Дотуур байрны гадна гэрэлтүүлэг-3ш-<b>300.000₮</b></p> <p>Нийт <b>2.513.200</b> төгрөг зарцуулсан.</p>		
3	3.	<p><b>2015.04.10 Дугаар 25</b> <b>Журамд өөрчлөлт оруулах тухай (Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам)</b></p> <p>2.Дээрх журмыг баталсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг холбогдох байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус даалгасугай.</p>	<p>Өмчийн тооллого хагас бүтэн жилээр Засаг дарга захирамжаар тооллого комисс томилогдон тооллого явуулдаг.Орон нутгийн өмч хөрөнгө актлах устгах хөрөнгүүдийг байгууллага тус бүр дээр өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хөрөнгүүдийн актлах хөрөнгө жагсаалтыг хэлэлцээд үндсэн хөрөнгийн актлах хүсэлтийг Өв аймгийн өмчийн хэлтэст хүргүүлж, сумын ИТХ-ын шийдвэр гарсаны дараа акталж, устгаж, шинээр бий болсон хөрөнгүүдийг бүртгэж авдаг. Энэ журмын хэрэгжилтийг ханган Батхаан багийн төвийн материалыг журмын дагуу бүрдүүлэн шийдвэрлүүлсэн. ЗДТГ-ын хоёр тээврийн</p>	100%	

			хэрэгсэлийн баримт бичгийг бүрдүүлэн дуудлага худалдааг зохион явуулж шийдвэр гарсан 2024 оны 9-р сарын байдлаар ангийн хамт олны хандиваар бэлгэлсэн 2500000 төгрөгний үнэтэй 2ш хивсийг орлогот бүртгэж авсан байна. ЭМТөв 2024 оны байдлаар багийн эмч нарт 4 ширхэг huawei брэндийн шинэ нөүтбүүк 8,276,000, автоклав-4,580,000, эмнэлгийн яаралтай тусламжийн автомашин-160,000,000, термостат-1,950,000, ус нэрэгч-647,000 зэрэг үнэ бүхий тоног төхөөрөмжийг орлогот бүртгэж авсан байна.		
4	4.	<b>2016.10.24 Дугаар 61 Журам батлах тухай (School police)</b> 2.“School police” эргүүлийн ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Я.Ганбат), журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар (Ч.Самбуу-Ёндон), Ерөнхий боловсролын сургуулиудад үүрэг болгосугай.	“School police” эцэг,эх,асран хамгаалагчдын эргүүлийг анги бүлгээр хуваарь гарган өдөрт 4 эцэг,эх ээлжээр жижүүрлэн ажилладаг. Эргүүлд гарсан эцэг, эхчүүд жижүүрлэх хугацаандаа ажилласан талаараа илтгэх дэвтэр гарган ажиллуулж байна. Эргүүлд ажиллаж буй эцэг, эхчүүд маань сурагчдын хичээлд оролт, гаралт, болзошгүй эрсдэлээс хүүхдийг хамгаалах талаар жижүүр багш нартай хамтран ажиллаж байна.	90%	
5	5.	<b>2017.02.03 Дугаар 15 Таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах тухай</b> 3.Уг тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд), аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир),	Бөмбийн атаршсан талбайг эргэлтэд оруулж 600 га талбайд малын тэжээл тариалж, 9,5 га талбайд төмс тариалж, 90 тн ургац, Хүнсний ногоо 8 га талбайд тариалж, 75 тн ургац хураан авсан.	100%	

		Мэргэжлийн хяналтын газрын дарга(С.Дуламсүрэн), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ч.Гүнсэнхорол), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.			
	6.	<b>2018.06.27 Дугаар 08/02</b> <b>Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг тогтоох тухай</b> 2.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварыг тогтоосон хэмжээний дагуу татварыг төлүүлэн ажиллаж байна 2024 оны төлөвлөгөө 21000,0 төгрөг төвлөрүүлэхээс 19000,0 төгрөг төвлөрүүлж 90 хувийн гүйцэтгэлтэй байна.	90%	
7	7.	<b>2018.06.27 Дугаар 08/05</b> <b>Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай</b> 2. Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон хувиар ногдуулах ажлыг зохион байгуулж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.	Улсын тэмдэгтийн хураамжийг тогтоосон хувь хэмжээний дагуу ногдуулан төлүүлж төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна. 2024 оны төлөвлөгөө 1500,0 төгрөг төвлөрүүлэхээс 3000,0 төгрөг төвлөрүүлсэн.	90%	
	8.	<b>2018.06.27 Дугаар 08/07</b> <b>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах, хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох тухай</b> 2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах журмыг батлан хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.	ТСҮХД-ын гэрээт хамгаалагчидтай биечлэн уулзаж, хариуцсан ТСҮХД-ын хамгаалалтад хяналт тавин ажилласан.	70%	
9	9.	<b>2018 Дугаар 36</b> <b>Сум хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийн тухай</b>	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний хугацаа дуусаагүй идэвхтэй байгаа 12 зээлдэгч байна. Үүнээс зээлийн гэрээний хугацаа	90%	

		Аймаг, сумын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт даалгасан.	дууссан, явцын хугацаа хэтрэлттэй зээлдэгч байхгүй хуваарийн дагуу эргэн төлөлтөө төвлөрүүлэн ажиллаж байна. Хоршоо хөгжүүлэх сангийн товыг хурлаар 2 удаа тогтоож, төслийг зарласан боловч одоогоор санд төсөл ирээгүй байна. Идэвхтэй байгаа зээлдэгч нарыг хоршоо хөгжүүлэх сангийн программд оруулж, сар бүрийн төлөлтийг шивж төв рүү дамжуулан ажиллаж байна. Аймгийн хоршоо хариуцсан мэргэжилтэн, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нартай хамтран хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгч нараар явж хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан.		
10	10.	<b>2018.11.12 Дугаар 77</b> <b>Аймгийн хөтөлбөр батлах тухай (Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр 2019-2024)</b> 2.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д даалгасугай.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох төсөл хөтөлбөрт шаардлага хангасан иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулаж сумын группээр төсөл хүлээн авах зар мэдээлэл бэлтгэн 2-3 удаа тавьсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд 2 эмэгтэй төсөл авсан байна. 3-р багийн иргэн Ч.Бадамцэцэг оёдол, монгол дээл хувцас урлах. Төсөл 5 сая, ОНОТХҮ-ний бүлийн төсөлд 5-р багийн өндөр настан Ч.Балжинням хүлэмж нарийн ногоо тарих бүлийн төсөл дэмжигдэж 2 сая санхүүгийн дэмжлэг авч тус тус ажлын байртай болсон. Нийтийг хамарсан ажлаар нийтийн эзэмшлийн гудамж талайд бүтээн байгуулалт хийх ажлын хүрээнд ажилгүй 68 иргэнийг түр ажлын байраар хангасан байна. үүнээс 26 эмэгтэй түр ажлын байранд зуучлагдан ажилласан. Төсөвт байгууллагат 9 эмэгтэй ажилд орсон байна. Хөдөлмөрийн тухай болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар эмэгтэйчүүдэд утсаар, цахимаар, үйлчилгээ	90%	

			авсан иргэдэд мэдээлэл хүргэж ажиллалаа. Цалинтай ээж хөтөлбөрт 132 эх хамрагдаж, 79,2 сая төгрөгний тэтгэмж авсан байна.		
11	11.	<p><b>2019.08.29 Дугаар 56</b>  <b>Хөтөлбөр батлах тухай. (Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр 2019-2024)</b></p> <p>2. Хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талын туслалцаа дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, Улаан загалмайн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулахтай холбогдсон зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Монголын улаан загалмайн нийгэмлэгээс зохион байгуулсан МУЗН-ийн Хүүхэд залуучуудын хөгжлийн төвд болсон сургалтад 2024.05.15-аас 2024.05.17-ны өдрүүдэд хурлын нарийн бичгийн дарга, мэргэжилтэн, сайн дурын идвэхтэний хамт хамрагдсан. Монголын улаан загалмайн нийгэмлэг, олон улсын улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад туслах хөтөлбөрийн хүрээнд тус сумаас 45 өрхөд 550,0 мянган төгрөгийн нийт 24750,0 мянган төгрөгний тусламжийг олгосон байна. Мөн 18 өрхөд хүнсний тусламжийг олголоо. 30 өрхөд эрдэс тэжээлийн багц олгосон байна.</p> <p>Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан цахим сургалтад өсвөрийн улаан загалмайн бүлэг, бүлгийн ахлагч, бүлэг удирдсан багшийг хамруулж, улаан загалмайн хөдөлгөөний үйл ажиллагааны талаар ойлголт мэдлэгтэй болгосон.</p>	100%	

12	12.	<p><b>2020.01.31 Дугаар 12</b>  <b>Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай</b></p> <p>1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хог, хаягдал боловсруулах үйлдвэр барих асуудлыг судлан шийдвэрлэх, энэ чиглэлээрх санал, санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.</p> <p>2.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах, тогтвортойгоор ажлуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах,бохирдуулагч нь төлбөр төлөх, зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсарыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж СИТХ-ын 2024.02.21 02 тоот тогтоолоор батлуулан ажиллаж байна.</p> <p>Хөрсний доройтолыг бууруулах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сааруулах, хамгаалах хог ангилан ялгах хоёрдогч түүхий эд авах хашаа барих ажил 2023.06 сард хийгдсэн. Цаашид хашааг тохижуулан хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмжийг суурьлуулж ашиглах ажил хийгдэнэ.</p>	90%	
13	13.	<p><b>2020.03.10 Дугаар 19</b>  <b>Зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай</b></p> <p>1. Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд хепатитийн В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдах зорилтот насны эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх боломжтой 9848 иргэнийг даатгалд хамруулах, даатгалаа төлөх боломжгүй 3165 иргэний илрүүлэг шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурын зардлын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхийг</p>	<p>Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд хепатит В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд зорилтот бүлгийн нийт 320 иргэнийг хамруулсан байна. Үүнээс эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй 89 иргэн хамрагдсан. Даатгал төлөх боломжтой 231 иргэн хамрагдсан Шаардлагатай тохиолдолд хепатит В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд иргэдийг хамруулан илэрсэн тохиолдолд дээд</p>	90%	

		аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д даалгасугай.	шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээн ажиллаж байна Шинээр В вирус-1 Хуучин С вирус-1		
14	14.	<b>2020.03.10 Дугаар 20</b> <b>Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө, зардал батлах тухай.</b> 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, зардлын зарцуулалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Ганболд, аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Т.Ариунболд нарт даалгасугай.	Байгаль хамгаалах сангийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайлан БНАТ-2, БНАТ-26 тайлангуудыг Байгалийн нөөц ашиглалтын нэгдсэн системд тогтоосон хугацаанд оруулж ажилласан байна. Иргэд олон нийтэд болон ЕБС-ийн сурагчидад ховор ан амьтан болон хог хаягдал, мод бут тарих, байгаль хамгаалах тухай хуулиар танхимын болон цахим хэлбэрээр сургалт зохион байгуулсан.	90%	
15	15.	<b>2020.12.02 Дугаар 03/02</b> <b>Өвөрхангай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай</b> 2.“Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд”-д тусгагдсан зорилт, арга хэмжээг тухайн жилийн “Жилийн хөгжлийн төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.	Өвөрхангай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-д тусгагдсан зорилт, арга хэмжээг сумын тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийг сумын иргэдийн төлөөлөгчдын хуралд тайлагнаж хэвшээд байна.	90%	
16	16.	<b>2020.12.02 Дугаар 03/03</b> <b>Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай</b>	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны	100%	



		2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны нэгдүгээр улиралд багтаан баталж, аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.	хөтөлбөрийг 2021 оны нэгдүгээр улиралд багтаан баталж биелэлтийг жил бүр сумын ИТХ-д тайлагнаж байна.		
17	17.	<b>2021.05.06 Дугаар 04/02</b> <b>Журам шинэчлэн батлах тухай (аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам)</b> 2.Журмын захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдсэний дараа аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлж, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.	Хүнсний байцаагч нарт байцаагчийн дүгнэлт гаргуулах албан тоот хүргүүлж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах аж ахуй нэгжийн материалыг хүлээн авч орон тооны бус зөвлөл хуралдаж, хяналт шалгалтыг зохион байгуулж 7 дэлгүүрийн тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг хавсаргах материал, албан тоотын хамт хууль зүйн хэлтэст хүргүүлж 5 жилээр сунгасан. Нэг дэлгүүрийн байцаагчийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүргүүлээд байна.	90%	
18	18.	<b>2021.04.30 Дугаар 35</b> <b>Шатар хөтөлбөр батлах тухай (2021-2024)</b> 2.Шатар хөтөлбөрийг сум, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд тусган ажиллахыг сумын Засаг дарга нарт, шатрын спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололтой тал нь: -Сурагчдын шатар тоглох сонирхол нэмэгдэж, тэмцээн уралдаанд идэвхтэй оролцдог болсон- Сургуулийн зүгээс өөрт бүрдүүлсэн нөөц шатраараа дотуур байрны тасаг бүрийг шатраар хангасан ба одоо сурагчдынхаа өөрсдийн шатраар шатрын дугуйланг хичээллүүлж байна. Дотуур байранд амьдарч байгаа сурагчдыг шатраар хичээллэх сонирхолыг дэмжих үүднээс тасаг бүрийг шатраар ханган ажилласан.	90%	

			<p>Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон дутагдалтай тал нь: - Манай сургуулийн хувьд 2 ээлжээр хичээллэдэг учраас Шатрын дугуйланг хичээллэхэд сурагчдынхаа чөлөөт цаг, багшийн хичээлийн бус цагийг тохируулж хичээллэж байна. Мөн шатрын цаг байхгүйгээс сурагчид гадагш тэмцээнд оролцохдоо тактикийн хожигдол нэлээдгүй хүлээж байна. <b>Цэцэрлэг:</b> Бүлгийн багш нар хичээлийн жилд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд шатар бүлэг сэдвийг оруулж шатрыг таних, нэрлэх, өрөх, тоглох чадваруудыг үе шаттайгаар эзэмшүүлж ажилласан. Ахлах бүлгийн хүүхдүүд шатрыг 100% өрж, нэрлэж сурсан. Бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд шатрын тоглох шатны мэдлэгийг үе шаттайгаар олгож шатрын дугуйланг Г.Наранцэцэг багш хариуцан явуулж 2024 онд 28 хүүхдэд \давхардсан тоогоор\ тоглох шатны мэдлэгийг олгож ажиллаж байна. Аймгийн аварга шалгаруулах “Унагалдай-2024” тэмцээнд амжилттай оролцож эрэгтэй төрөлд 68 хүүхдээс Н.Эрдэнэбаяр 10-р байр, У.Есөнбилэг 11-р байр, Х.Энхбаяр 13-р байрт, эмэгтэй төрөлд 22 хүүхдээс О.Энх-Энэрэл 12-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн. ЕБС-ийн технологийн багш М.Баасанхүүг урьж авчирч шатрын тоглолт заалгасан. Г.Наранцэцэг багш нь шатрын Online сургалтанд хувиараа</p>		
--	--	--	---	--	--

			төлбөрөө төлөн хамрагдаж өөрийн мэдлэгээ дээшлүүлж ажилласан.		
19	19.	<p><b>2021.06.07 Дугаар 37</b>  <b>Хөтөлбөр батлах тухай</b>  <b>(Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 2021-2024)</b></p> <p>2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж, хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p> <p>3.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Архины хамааралтай иргэдэд мэдээллийг хүргэж ажилласнаар архи уух давтамж холдож зарим иргэд архины хэрэглээнээс татгалзаж чадсан. Гэр бүлдээ амар тайван амьдарч эхэлсэн. Хүүхдийнхээ дэргэд архидан согтуурсан гэр бүлийн гишүүд хорт зуршлаасаа хөндийрч хүүхэддээ хандах хандлага эрс сайжирсан. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийлэгч нар сэтгэл зүйчтэй 1-2 удаа уулзаж сэтгэл заслын үйлчилгээ авч зан үйлээ засч хандлагаа өөрчилсөн. Хорт зуршил сонирхогч хүүхдийн тоо бууруулж асуудлыг таслан зогсоох арга хэмжээ авч ажилласан. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид мэдээлэлтэй болж хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа, хүүхэд ажиллагсдын хараа хяналт сайжирсан. Төслийн хугацаанд 2-3 удаа нөхцөл байдал үнэлж тухайн өрхийн хэрэгцээг тодорхойлж зөвлөн тусалж хамтран ажилласнаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргаа сувилгаа, хараа хяналт сайжирсан. Гэр бүлийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нар сэтгэл заслын анхан шатны үйлчилгээ авч хандлага өөрчлөгдсөн</p> <p>Архины хамааралтай болон кейс үйлчилгээ үзүүлж буй иргэдийн төлөөлөл 2 удаагийн сургалтаар 36 иргэн төслийн үр шим хүртэгч нар хамрагдсан.</p>	90%	
20	20.	<p><b>2021.07.08 Дугаар 05/05</b>  <b>Сум дундын отрын нөөц нутаг, түүний хилийн зааг тогтоох тухай</b></p>	<p>Аймаг дундын ортын бүс болох аймаг Хөх дэлийн Отрын бүсэд Бүрд сумын 4 өрх, Баян-Өндөр сумын 9 өрх нийт 13 малчин өрхийн 1904</p>	70%	

		1.Сум дундын 626 312.6 га отрын нөөц нутгийг зохистой ашиглах, хамгаалах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.	бод, 9134 бог мал өвөлжиж хаваржихаар захиалга хүргүүлээд байна.		
21	21.	<p><b>Дугаар 66</b>  <b>Хөтөлбөр батлах тухай 2021-2024</b>  Нэг өрх-Нэг ажлын байр: Орон нутгийн зорилтот бүлгийн иргэдэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, салбар дундын уялдаа холбоонд тулгуурлан хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлж, нэг өрхөд нэг ажлын байр бий болгох замаар тэдгээр өрхийн амьралын чанарыг сайжруулах</p>	Хөтөлбөрт хамрагдсан өрх иргэдийг судалгаагаар өрхийн иргэн бүрээр гаргалаа. Хөтөлбөрт 8 өрхийн 39 иргэн хамрагдаж байна. Иргэдийн 16 нь 18 аас дээш насны иргэд байна. Хөтөлбөрт хамрагдаж байгаа. Өрхөөс Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэн Д.Нармандах ногоон тэжээл тарих төсөл 5 сая, Ш.Цолмонбаяр модон эдэл хийх төсөл 5 сая төгрөгний ХЭДС-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан. Мөн Б.Зоригтбаатар ЗДТГазарт хог ачих үйлчилгээны ажилтан, Суманд барагдаж байгаа шинэ эмнэлэг, сургууль дээр 4 иргэн түр ажлын байраар ханган ажилсан. Тухайн өрхийн орлого нэмэгдэж, амьдралд ахиц гарч байна. Одоогийн байдалаар 1 иргэн төсөвт байгууллагад 2 иргэн төсөл авч өрхийн орлоготой болсон 4 иргэн малчнаар ажиллаж байна. Эдээр иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч зохих түвшний сургалтанд хамрагдаж, боловсролын түвшин дээшилсэн байна.	90%	

22	22.	<p><b>2022.01.28 Дугаар 08/04</b>  <b>“Сумдын газрын үнэлгээний бүсийн зураг, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай”</b>  2.Газрын төлбөрийн бүсчлэл, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д үүрэг болгосугай.</p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 08/04 дүгээр тогтоолоор “Арвайхээр, Хархорин болон бусад 17 сумдын газрын үнэлгээний бүс, газрын суурь үнэ, итгэлцүүр”-ийг шинэчлэн батлуулсан. Энэ тогтоол нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэн <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a> сайтад бүртгэгдсэн. Газрын үнэлгээний бүс шинэчлэн тогтоосонтой холбогдуулан газрын кадастрын мэдээллийн системд Баян-Өндөр сумын газрын суурь үнэ, газрын төлбөрийн итгэлцүүр, дуудлага худалдааны итгэлцүүрийг шинэчлэн оруулж, газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэж байна.</p>	100%	
23	23.	<p><b>2022.02.25 Дугаар 09/06</b>  <b>“Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал батлах тухай”</b>  2.Төсвийг батлагдсан дүнд багтаан зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Сумын Засаг даргын 2023 оны 12-р сарын 26 ны өдрийн А/197 тоот захирамжаар батлагдсан сар улирлын хуваарийн дагуу төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна. Сангийн сайдын 190-р журмын дагуу гүйлгээг хянан баталгаажуулж, төсвийг үр ашигтай зарцуулан ажиллаж байна.  <b>ЭМТөв:</b> Байгууллагын төсвийг батлагдсан дүнд нь багтаан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тухайн байгууллагын хэрэгцээ шаардлага, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан ажиллаж байна.</p>	100%	

24	24.	<p><b>2022.02.25 Дугаар 09/09</b>  <b>“Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө” батлах тухай</b></p> <p>2.Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөөтэй уялдуулан сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан төсөв санхүүг жил бүр аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах, тогтвортойгоор ажиллуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах,бохирдуулагч нь төлбөр төлөх, зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсарыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж СИТХ-ын 2024.02.21 02 тоот тогтоолоор батлуулан ажиллаж байна.</p>	90%	
25	25.	<p><b>2022.09.23 Дугаар 13/03</b>  <b>“Хөтөлбөр батлах тухай”</b></p> <p>1.Өвөрхангай аймгийн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.  2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр ханган, шаардагдах хөрөнгийг эрүүл мэндийн салбарын төсөвт жил бүр тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Хөтөлбөрийн хүрээнд хүний нөөцийг нэмэгдүүлэн эмч эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэн сар бүр тогтмол эмнэлзүйн сургалт багийн эмч нарыг чадавхжуулах сургалт, сувилагч, удирдлагыг чадавхжуулах богино хугацааны гадаадад дахь сургалтад хамрагдан ур чадвар арга зүйгээр ханган ажиллаж байна.</p>	90%	
26	26.	<p><b>2022.09.23 Дугаар 13/04</b>  <b>“Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг тогтоох тухай”</b></p> <p>2.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай” аймгийн ИТХ-ын 2022 оны 09 сарын 23-ны өдрийн 13/04 тоот тогтоолыг засгийн газарт уламжилсан.  Газрын тухай хуулийн 29.1, 29.2, 29.3, 54.1, 56.1.1, Хот байгуулалтын тухай хуулийн 24.2, Авто замын тухай хуулийн 16.2, ашигт малтмалын лицензийн талбай, улсын тусгай хэрэгцээний газартай давхцуулсан, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй зэрэг</p>	90%	

			үндэслэлээр Баян-Өндөр суманд газрыг өмчлүүлэх боломжгүй болсон байна.		
27	27.	18.2.Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэгжүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлэн зарлага санхүүжилтыг гүйцэтгэж байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.	Сумын ИТХ-аар батлагдсан орлогыг нэр төрөл тус бүрээр , төвлөрүүлж , зарлага санхүүжилтийг сар улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэн ажиллаж байна. Соёл: 2024 оны 1-9р саруудад 139.390.000 төгрөгний улсын төсвийн санхүүжилтээс 138.622.700 төгрөгний санхүүжилт авч авч гүйцэтгэлийг 95.6% зарцуулж тайлагнасан. Цэцэрлэг:Тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан санхүүгийн сахилага батыг баримтлан өр авлага үүсгээгүй ажилласан. ЭМТөв: 2024 оны 1-9-р сард нийт 735,721,000.79 төгрөгний улсын төсвийн санхүүжилтээс 623,136,438.01 төгрөгний санхүүжилт авч авч гүйцэтгэлийг 87,6% зарцуулж тайлагнасан.	100%	
	28.	18.3.Төсвийн сахилга хариуцлагыг сайтар ханган ажиллаж, төсвийн гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэн, өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласугай.	Сумын төсвийг нэвтрэлтийн нэгдсэн системээр бүх гүйлгээг хянан баталгаажуулан хийж зориулалт бус гүйлгээ байхгүй.Сумын нэгдсэн тайлан болон байгууллагуудад хийгдсэн аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлт авсан.Акт албан шаардлага авсан байгууллага байхгүй Соёл: 2023 оны санхүүгийн тайланд гүйцэтгэлийн аудит хийгдэж зөрчлилгүй, албан шаардлага аваагүй болно. Цэцэрлэг: Хагас бүтэн жилээр төсвийн аудитын хяналт шалгалтанд орж зөрчил дутагдалгүй ажилласан ЭМТөв: 2023 оны санхүүгийн тайланд гүйцэтгэлийн аудит хийгдэж зөрчлилгүй, албан шаардлага аваагүй болно.	100%	

29	29.	<p><b>2023.04.14 Дугаар 18/01</b>  <b>“Дуудлага худалдааны орлого хуваарилах тухай”</b>  1.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдааны орлогын 60 хувийг аймгийн төсөвт, 40 хувийг тухайн сумын төсөвт тухай бүр төвлөрүүлсүгэй.</p>	<p><b>“Дуудлага худалдааны орлого хуваарилах тухай”</b> тогтоолыг 2023 оны 10 сараас эхлэн аймаг сумдын төрийн сан мөрдөж ажиллаж байна.  Сумын 2023 оны ГЗБТ-д Дуудлага худалдаарар эзэмшүүлэх нэгж талбар тусгагдаагүй. 2024 оны ТЖГЗБТ 4 нэгж талбарт газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалгааг зохион байгуулж 754,000/ долоон зуун тавин дөрвөн мянга/ төгрөг сумын Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. 2023.04.14 өдрийн 18/01 дугаар тогтоолын Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдааны орлогын 40 хувийг тухайн сумын төсөвт хуваарлахаар ажиллаж байна.</p>	90%	
30	30.	<p><b>2023.06.27 Дугаар 20/04</b>  <b>“Хөтөлбөр батлах тухай”</b>  1.Аймгийн нийт мал сүргийн бүтцийг сайжруулах, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор “Үхэр сүрэг” хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, хөтөлбөрийн санхүүжилтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.  2.“Үхэр сүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Үхэр сүргийг малчдад таниулж 120-оос дээш үхэр тоолуулсан малчдад аймгийн аварга малчин болох болзолыг танилцуулан ажиллаж байна. Шинээр байгуулсан хоршоодод сайн чанарын үхэр худалдан авч нийлүүлэх үхрийн ашиг шимийн талаар сурталчлан таниулж Алтан овоо салхит хоршоо үхэр өсгөх чиглэлээр 50,0 төгрөгийн төсөл бичиж шийдвэрлэх шатандаа явж байна.</p>	90%	



31	31.	<p><b>2023.09.27 Дугаар 22/02</b>  <b>Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай</b></p> <p>1.Аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоосугай.  2.Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг тогтоосон хувиар ногдуулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д даалгасугай.  3.Тогтоолын хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажилласугай.  4.Тогтоол хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай” 08/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>	<p>Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тогтоосон хувь хэмжээний дагуу ногдуулан татварыг төлүүлж төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна. 2024 оны төлөвлөгөө 2500,0 төгрөг төвлөрүүлэхээс 4940,0 төгрөг төвлөрүүлсэн байна.</p>	90%	
32	32.	<p><b>2023.11.29 Дугаар 23/03</b>  <b>Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын талаар авах арга хэмжээний тухай</b></p> <p>1.Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилтийг 46.7 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үзсүгэй.  2.Аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч И.Доржсүрэнд даалгах нь:  2.1. Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын зорилт тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан жилийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах,</p>	<p>Байгууллага бүрт хүүхэд хамгааллын бодлогыг эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллах чиглэл өгч ажилласнаар хүүхдийн төлөө хамгааллын үйл ажиллагааг байгууллага аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрч ажиллаж байна. Хүүхэд хамгааллын баг, хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж цаашид хүүхдийн хамгааллын асуудлаар зөрчилгүй сум болох зорилт тавин ажиллаж байна. Хүүхэд хамгааллын асуудлаар Дотуур байрны сурагчид, эцэг эх, багш, цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нар багш нарын хооронд гурвалсан гэрээг байгуулж эцэг эх, байгууллагын үүрэг хариуцлагыг</p>	90%	

	<p>хариулагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах</p> <p>2.2.Аймаг, сумын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хийсэн ажлыг олон нийтэд тайлагнах</p> <p>2.3.Аймгийн болон сумын ИТХ-аар хэлэлцэж батлах төсөвт хүүхэд хамгааллын бодлогын арга хэмжээнд болон “Хүүхдийн төлөө зөвлөл”, “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг нэмэлтээр тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах</p> <p>4.Аймгийн нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага бүр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”-ийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг үндэслэн Хүүхэд хамгааллын бодлого батлан хэрэгжүүлэх, эцэг, эхий зөвлөл байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг үүрэг болгосугай.</p> <p>5.Энэхүү тогтоолын 4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахад аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийтийн эзэмшлийн зам ,талбай, гэрээс гадуурх орчинд хүүхдэд эрсдэл учруулж болохуйц нөхцөл байдлыг дахин тогтоож, холбогдох байгууллагуудтай хамтран зөвлөмж боловсруулан хүргүүлж, анхааруулах арга хэмжээ авч, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлыг бүрдүүлж, учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллахыг аймгийн</p>	<p>танилцуулж гарын үсгээр баталгаажуулсан. Хүүхдэд ээлтэй дотуур байр, Хүүхдэд ээлтэй сургууль, ЭМТөвийг бий болгож хүүхдийн төлөө үүрэг хариуцагч нарыг үүрэгжүүлж ажилласан. Хүүхэд амьдрах орчин нөхцлийг эрүүл аюулгүй байлгах, зөвлөгөө мэдээллийг тогтмол өгөх, хүүхдийн төлөө үйлчлэгч нарт дотуур байранд гадны хүн нэвтрэхийг хориглосон журам мөрдөж ажиллах тухай зөвлөж ажилласнаар гадны хүн нэвтрэхийг хориглосон журам, камер ашиглалтын журмуудыг мөрдөж ажиллаж байна.</p>		
--	--	--	--	--

		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт үүрэг болгосугай.	Нийгмийн орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр: Гудамжны золбин нохойг гудамжны золбин нохойг устгаад байна. Эзэнтэй айлын нохойг уях мэдэгдэл хүргүүлсэн. Өсвөр үеийнхнийг архи согтууруулах ундаа тамхи худалдаалдаг дэлгүүрдэд насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэхгүй байхыг зөвлөж камерийн хяналтыг 2 удаа хийгээд байна. Насанд хүрээгүй хүүхэд замын хөдөлгөөнд оролцохгүй байх, жолоо барихыг хориглох. Замын хөдөлгөөнд насанд хүрээгүй хүүхэд тээврийн хэрэгсэл зорчихгүй байх сэрэмжлүүлэг өгч эргүүлийг 2 удаа гүйцэтгэсэн. Сургалт, мэдээ мэдээллийн чиглэлээр: Хэсгийн төлөөлөгчтэй хамтран ангиудаар явж ажиллахдаа осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл хийсэн. Замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдал сэдвээр сумын цагдаагийн ажилтан Ж.Өсөхбаяр ахлах ангийн сурагчдад сургалт хийсэн. Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн 13 сурагчид “Өсвөр сэргийлэгч бүлгэмд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. “Залилах гэмт хэрэг, Цахим хэрэглээнээс татгалзъя” сэдэвт сургалтыг явуулсан.		
33	33.	<p><b>2023.11.29 Дугаар 23/04</b>  <b>Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай</b></p> <p>1.Аймгийн хэмжээнд 2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.</p>	<p>Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай” аймгийн ИТХ-ын 2023.11.29-ний 23/04 дугаар тогтоолыг Засгийн газарт уламжилсан.</p> <p>2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 137 дугаар “Улсын хэмжээнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” тогтоолоор 727 иргэнд 38,27 га газрыг өмчлүүлэхээр тусгагдсан байна.</p>	90%	

		2.Энэхүү тогтоолыг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д даалгасугай.	Харин Газрын тухай хуулийн 29.1, 29.2, 29.3, 54.1, 56.1.1, Хот байгуулалтын тухай хуулийн 24.2, Авто замын тухай хуулийн 16.2, ашигт малтмалын лицензийн талбай, улсын тусгай хэрэгцээний газартай давхцуулсан, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй зэрэг үндэслэлээр Баян-өндөр суманд 68 нэгж талбарт газрыг өмчлүүлэх боломжгүй болсон байна.		
34	34.	<b>2023.11.30 Дугаар 23/10 Зорилтот жил зарлах тухай</b>  1.2024 оныг “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” жил болгон зарласугай. 2.“Цахим шилжилтийг эрчимжүүлэх” жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д даалгасугай. 3.“Цахим шилжилтийг эрчимжүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.	“Цахим шилжилтийг эрчимжүүлэх жилийн” хүрээнд сумын Засаг даргын 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/23 захирамжаар ажлын хэсэг гарч Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 07 дугаар тогтоолоор төлөвлөгөөг батлуулж зорилтот жилийн нээлтийн арга хэмжээнд ажлын хэсгийн ахлагч төлөвлөгөөг танилцуулсан. Мөн нээлтэд аймгийн ажлын хэсгийг урьж мэдээлэл хүргэн сургалт зохион байгуулсан. Өвөрхангай аймагт зорилтот жилийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсон. Хагас жилээр зорилтот жилийн үр дүнг иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнасан.	90%	
35	35.	<b>2024.01.29 Дугаар 24/02 “Журам батлах тухай”</b>  1.“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх,	Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгийг журмын дагуу орлогод авч, барилга байгууламж тээврийн хэрэгсэл түүнтэй холбоотой асуудлыг аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлж ажиллаж байна.	90%	

		шинэчилсэн үнэлгээ тогтоох журам"-ыг хавсралтаар баталсугай.  7.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны "Журам батлах тухай" 25 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.			
<b>ХЭСГИЙН ДУНДАЖ: 91.1%</b>					
<b>Аймгийн ИТХ-ын хуралдааны тэмдэглэлээс</b>					
36	36.	<b>2017.04.10. Дугаар 02</b> <b>Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан арга хэмжээ авч ажиллах тухай</b> -Сумдын ОНХС, сум хөгжүүлэх сангаас иргэд, аж ахуйн нэгжийн авсан хугацаа хэтэрсэн зээл, худалдан авах ажиллагааны хууль зөрчсөн байдал, зориулалт бусаар зарцуулсан зардлуудын талаар тодорхой ажлын чиглэл гаргаж, зээлийг эргэн төлүүлэх, буруутай хүмүүст арга хэмжээ тооцох, цагдаа, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллах.	Хоршоо хөгжүүлэх сангийн гэрээний хугацаа дууссан 1 зээлдэгчийн 3509699 төгрөгийг санд төвлөрүүлэн ажилласан. 2024 онд 11 зээлдэгч зээлийн гэрээний хугацаа дуусч зээлээ хаасан байна. Одоо идэвхтэй байгаа 12 зээлдэгч хуваарийн дагуу эргэн төлөлтөө хийж хугацаа дууссан, явцын хугацаа хэтрэлттэй зээлдэгч байхгүй байна.	100%	

**ХЭСГИЙН ДУНДАЖ: 100%**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

37	37.	<p><b>2018.07.24 Дугаар 01</b> <b>Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг зогсоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай</b></p>	<p>Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зорилгоор Өвөрхангай аймгийн болон Төв, Дундговь аймгийн зарим суманд малын гоц халдварт цэцэг өвчин оношлигдсонтой сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 тоот захирамжийн хүрээнд хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалтын ажлыг 3-н хэсэг гаргаж сумын хил залгаа 44 айл өрхийн малд үзлэг тандалт хийсэн. Тус ажлын хэсгийн тандалтын үр дүнд цэцэг өвчний сэжигтэй айл өрхийг илтүүлж 2024 оны 01 дүгээр сарын 24-ны А/24 тоот захирамжийн хүрээнд хязгаарлалтын дэглэм тогтоон ажилласан.</p> <p>Баян-Өндөр сумын 3,4 дүгээр багуудад 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Өвөрхангай аймгийн мал эмнэлгийн лабораторийн 24/20 дугаартай шинжилгээгээр хонины цэцэг өвчин гарсан нь батлагдсан тул 2024 оны 01 сарын 24-ны өдрийн А/06 дугаар захирамжаар Хязгаарлалтын дэглэмийг “Хорио цээрийн дэглэмд шилжүүлэн ажилласан. Энэ арга хэмжээнд 3,6 сард 63174 толгой малыг дархлаажуулалтанд хамруулсан байна. Мөн 8,9 дүгээр сард 149421 толгой малыг 99 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэлээ. Малын гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хонь 221605 толгой малыг хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажил хийгдэж байна.</p>	90%	
----	-----	---	---	-----	--

38	38.	<b>2019.7.25 Дугаар 01 “Сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг сайжруулах тухай”</b>	Хоршоо хөгжүүлэх сангийн гэрээний хугацаа дууссан 1 зээлдэгчийн 3509699 төгрөгийг санд төвлөрүүлэн ажилласан. 2024 онд 11 зээлдэгч зээлийн гэрээний хугацаа дуусч зээлээ хаасан байна. Одоо идэвхтэй байгаа 12 зээлдэгч хуваарийн дагуу эргэн төлөлтөө хийж хугацаа дууссан, явцын хугацаа хэтрэлттэй зээлдэгч байхгүй байна.	90%	
<b>ХЭСГИЙН ДУНДАЖ: 90.0%</b>					
<b>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ 2024 он</b>					
39	39.	<b>Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024.02.23 Дугаар А/118</b>	Тус сум нь гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэрийн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр А/22 тоот захирамж гарсаны дагуу өвөлжилт, хаваржилт хүндэрсэн айл өрхийн судалгааг тогтмол гаргаж, малын хорогдол, отор яваа өрхийн судалгаа, 3 үгт апп зэрэг мэдээ судалгааг тогтмол баяжуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус суманд МУЗГ-ын 449-р тогтоолоор 15тн хивэг, МУЗГ-ын 479 дүгээр тогтоолоор хуваарилсан 9тн хэвэг Сант сумын сумын улсын нөөцийн цэгээс татан авч малчин өрхөд хөнгөлөлттэй үнээр нь тараан олгож ажилласан байна. Мөн тогтоолоор хуваарилагдсан 2тн долооц, 2тн циолит эрдэст тэжээлийг татан өвч малчин өрхүүдэд үнэ төлбөргүй олгосон байна. Мөн аймгийн аюулгүйн нөөцөөс хуваарилсан 800 боодол ногоон тэжээлийг татан авч хөнгөлөлттэй үнээр иргэдэд олгох ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан байна. Дээрхи тусламжийн өвс тэжээлийг татан авах, ачих буулгах тараахад	100%	

			<p>сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн алба хаагчдыг дайчлан ажиллуулсан байна.</p> <p>2. Тус суманд Е440-293 улсын дугаар УРАЛ автомашин 2024 оны 03 дугаар сарын 5-ны 23.10 цагт Хорхорин сумаас шилжин ирсэн байна. 2024.03.03-ны өглөө 10.00 цагт 2 дугаар баг /Батхаан/-т ажиллахаар 40 боодол өвс, 4 шуудай хужир ачиж хөдөлгөөн үйлдсэн байна. Ховор ан амьтанд биотехникийн арга хэмжээ авахаар 20 боодол ногоон өвс, 4 шуудай хужир тээвэрлэж зам гаргаж Аргалын ууланд хүргэсэн байна. Аргалын ууланд биотехникийн арга хэмжээ авах, өвс, хужир тавьж өгөх БОХУБайцаагч Д.Рагчаагаар ахлуулсан 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон ажиллаж ирсэн байна. Ууланд 5-6 тоо толгойны аргал угалз байна. Хаваржилтийн хувьд одоогоор цутралгүй давгүй сайхан орсон байна гэх мэдээллийг авч ирсэн байна.</p> <p>Урал автомашин Гуагийн хөтөлөөс хойш 15 айл өрхийн хаваржаа руу дальпуу чирж зам гаргах ажлыг шуурхай зохион байгуулсан байна. 17.30-д ӨВ.Бүрд сумын нутагт ажиллаж байсан ЗИЛ-131 маркын автомашин эвдэрсэн тул түүнийг чирж Бүрд сум орохоор явлаа. 2024 оны 03 дугаар сарын 19.00 цагт ирж Шөнийн 11.00 цаг өнгөрч байхад Д.Баяраа, Ж.Эмээл, Ж.Мөнхсайхан нарын оторт байгаа /ДУ.Сайхановоо сумын нутаг Их овоо, Дундын нуруу гэх газарт байх/ айлд 10 боодол өвс, 40</p>		
--	--	--	---	--	--



			<p>боодол ногоон тэжээл, 8 шуудай хужир хүргэх ажлыг зохион байгуулж ирсэн байна.</p> <p>2024.03.08-ны өглөө 09 цагийн үед Өвөрзүлэгт 3 дугаар багийн нутгаас өвс тэжээл хивэг, долооц, эрдэст тэжээлийг 28 өрхөд хүргэж өгөх шаадлагатай газар оронд зам гаргах ажлыг зохион байгуулсан байна. Энэ хугацаанд нийт 1012 литр шатахуун зарцуулсан 800 гаруй км замыг туулж, өвс тэжээл хүргэх, татах, зам даваа гаргах ажлыг шуурхай зохион байгуулсан. 3 дугаар сарын 8-ны орой УБ хот руу буцах замд манай сумын буяны ажилд ирж явсан автомашин цасанд сууж хоносон дуудлага ирсэн тул татан гарган төв замд оруулж өгөөд буцсан байна. Эн ажилд нийт 15 албан хаагч дайчлагдан ажилласан байна.</p> <p>3.Өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор амьжиргааны эх үүсвэрээ алдаж, мал сүргээ 60-аас дээш хувийн хорогдолтой 19 өрх айлыг нарийвчлан судалж биечлэн холбогдож мэдээллийг цуглуулж холбогдох дээд шатанд хүсэлт тавьсан байна. Мөн 38 өрхөд ЭМ-ийн үйлчилгээг хүргэхэд хүндрэлтэй судалгааг гаргаж холбогдох дээд шатны байгууллага хүрч үйлчилсэн байна. Өвс тэжээлийн нөөцөө дууссан 500 гаруй айл өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, иргэн хувийн аж ахуйн нэгжтэй хамтран өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлж хангалтыг шуурхай зохион байгуулж ажилласан байна.</p> <p>Сумын аюулгүйн нөөцийн 20тн тэжээл, тн өвсийг 3 удаагийн давтамжтайгаар иргэд олгох</p>		
--	--	--	--	--	--

			<p>ажлыг сумын онцгой комиссын шийдвэрээр олгож ажилласан байна.</p> <p>4. Шар усны үерийн эрсдэлд орох магадлалтай айл өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, нийт 10 айл өрх байгаа бөгөөд төлөвлөгөөг гаргаж нүүлгэн шилжүүлэх хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажилласан байна. Мөн сумын хэмжээнд шар усны болон уруйн үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг шуурхай штабын бие бүрэлдэхүүн, ХАА-н тасаг, цаг уурын эрхлэгч нартай хамтран гаргаж ДУНД түвшинд үнэлэгдсэн байна.</p>		
40	40.	<p><b>Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай 2024.03.13 №А/193</b></p>	<p>Сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/36 тоот захирамжийн дагуу мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 6-н нэр төрлийн арга хэмжээнд малыг хамруулахаар төлөвлөлтийг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд ДХХ вакцинаар 29.0 мал хамрагдахаас 28960 хамрагдаж гүйцэтгэл 99.8 дуут үхэрт төлөвлөлт 1,0 малаас 980 гүйцэтгэл 98%, цусан халдварт төлөвлөлт 2,0 гүйцэтгэл 1990 99.5%, ДХХ энтеробактериоз төлөвлөлт 23.0 гүйцэтгэл 22960 99.8 % шөвөг яр төлөвлөлт 11.0 гүйцэтгэл 10964 буюу 99.6% сахуу төлөвлөлт 1.6 гүйцэтгэл 100 хувьтай тус тус хийж гүйцэтгэсэн. Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2024 оны төл мал тугал 2800, хурга-55.0, ишиг 27800 төлөвлөн арга хэмжээ хийгдэж байна.</p>	90%	

41	41.	<b>Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийг даатгалд хамруулах тухай</b> <b>2024.03.28 Дугаар А/239</b>	Тээврийн хэрэгслийн албан татварыг тогтоосон хэмжээний дагуу төлүүлэн ажиллаж байна 2024 оны төлөвлөгөө 21000,0 төгрөг төвлөрүүлэхээс 19000,0 төгрөг төвлөрүүлж 90хувийн гүйцэтгэлтэй байна.	90%	
42	42.	<b>Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай</b> <b>2024 он. Дугаар А/635</b>	Сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09 ны А/123 дугаар захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулж 8 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Өвөлжилтийн бэлтгэлийг хянаж шалгах сумын ажлыг хэсэг удирдамж батлуулан албан байгууллага, аж ахуйн нэгж, малчдын өвөлжилт хаваржилтын бэлчээрийн даац, сумын өвсний фондын аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтэд анхаарч ажиллалаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>➤ Өвөлжилт хаваржилтын төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 29 заалтыг төлөвлөн хэрэгжүүлж биелэлтэнд хяналт тавих Засаг даргаар батлуулсан удирдамжийн хүрээнд албан байгууллага аж ахуйн нэгж, малчдын өвс тэжээл бэлтгэлтийн явцыг хянаж шалгасан.</li> <li>➤ Сумын аюулгүй нөөцөд 50 тонн өвс, 40 тонн тэжээлийг төвлөрүүлсэн. Малчдын бэлтгэх өвс 1830 тонн, гар тэжээл 620 тонн, хужир шүү 1240 тонныг тус,тус бэлтгэсэн байна.</li> <li>➤ 2024 оны 10 сарын байдлаар мах адуу 2,0 тонн, хонины мах 7295кг, ямааны мах 4900 кг , мал гарал үүслээр адуу 82, үхэр-20, хонь 5236, ямаа 256 толгойг тус,тус</li> </ul>	90%	

			<p>эдийн засгийн эргэлтэнд оруулсан байна. 2024-2025 онд өвөлжих болон сүргийн зохистой харьцаанд тулгуурлан эдийн засгийн эргэлтэнд аж ахуйн нэгж, малчидаас адуу -920, үхэр 360, хонь-91500, ямаа, 46100 буюу нийт 138800 толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Орон нутгийн болон аймаг дундын улсын тусгай хэрэгцээний отрын нөөц нутагт өвөлжүүлж, хаваржуулах 26 малчин өрхийн 15735 толгой мал өвөлжүүлэхээр судалгаа гаргасан</li> <li>➤ Бөмбийн тариалангийн талбайд 70 өрхийн тариалсан ногоон тэжээл, байгалийн хадланг орон нутагтаа нөөц бүрдүүлэлтэнд 1830 тонныг нөөц бүрдүүлэх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж байна</li> <li>➤ 2024 онд 60,0 сая төгрөгөөр 4 цооног гаргасан</li> </ul>		
43	43.	<b>Цэргийн жинхэнэ албаны халалт, татлагыг зохион байгуулах тухай 2024.09.12 №А/717</b>	Цэрэг татлага явуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/717 тоот захирамж, Сумын засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны А/126 тоот захирамжаар 19 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр суманд амжилттай зохион байгууллаа. Нийт 126 залуус биеэр ирж орсон бол нэгдүгээр курсын оюутан 12, 1998 оны залуус ирж хаалгаж мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн байна. 6 цэрэг	100%	

		тэнцсэн байна. цэрэг татлага зохион байгуулах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэж ажилласан.		
<b>ХЭСГИЙН ДУНДАЖ: 94.0%</b>				
<b>ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ: 93.7%</b>				

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЦЭРЭНСУГАР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СОНИНБАЯР